



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А1116

Улаанбаатар хот

Налайх дүүргийн “Ачлал Налайх” БГБХН
өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус
хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,520,000.00 (гурван сая таван зуун хорин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвд хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг “Ачлал Налайх” БГБХН өрхийн эрүүл мэндийн төв (А.Даваасүрэн)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв (Л.Байгал)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 06 өдрийн 116 дугаар тушаалын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСТ ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллага: Налайх дүүргийн Ачлал налайх БГБХН өрхийн эрүүл

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон өн	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Нярайн шарлалтын аппарат	2023.09.06	ш	1	3,520,000.00	3,520,000.00	645,333.30	2,874,666.70	Ачлал налайх ӨЭМТ	НДЭМТ
	Дүн			1		3,520,000.00		-		